



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/204

Улаанбаатар хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
хүчингүй болгож, газар эзэмших эрхийг
дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.4, 35 дугаар зүйлийн 35.3.1, 39 дүгээр зүйлийн 39.1.4, 40 дүгээр зүйлийн 40.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/451 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газрын тухай хууль тогтоомж, газар эзэмших гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа ноцтой зөрчсөн, төлбөрөө хугацаанд нь бүрэн төлөөгүй 1 (нэг) аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, газар эзэмших эрхийг дуусгавар болгосугай.

2. Энэ захирамжийн хавсралтад заасан аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийн гэрчилгээ нь хүчингүй болсон тухай зохих журмын дагуу мэдэгдэж, газар эзэмшүүлэх гэрээг цуцлан, газрын кадастрын мэдээллийн сангийн бүртгэлд өөрчлөлт оруулах, хяналт тавьж, ажиллахыг Багахангай дүүргийн Газар зохион байгуулалтын алба (Ч.Магадсайханд)-нд даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан дүүргийн Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/113 дугаар захирамжийн "Хөшөө цайдам" ХХК-д хамаарах заалтыг тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД



Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 сарын 08-ны өдрийн 108 дугаар
захирамжийн хавсралт

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ НЬ ХҮЧИНГҮЙ БОЛГОЖ
БАЙГАА ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

Д/д	Газар эзэмшигч ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллагын		Газрын				Өмнө нь гарсан ДЗД-ын захирамж шийдвэр
	Нэр	Регистр	Байршил	Зориулалт	Хэмжээ м2	Эдэлбэрийн хэлбэр	
1.	"Хөшөө цайдам" ХХК	2040255	2-р хороо	Орон сууцны барилга	470	Эзэмших	2016 оны А/113